

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/009/НА-СТА-ТТЗ

| | |
|--|--|
| Цахим хуудас: www.audit.mn | Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn |
| Алтай хот | Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn |
| 2026 он | Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhandd@audit.gov.mn |
| | Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



Г ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
Б.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 25 № 150

танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чандмань сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Малын тоо толгойн албан татвар 11.4 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 4.8 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.5 сая төгрөгөөр тус тус тасарсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бэлэл дурсгал, шагналд 8.8 сая төгрөг зарцуулсан,
- Сумын Засаг даргын Тамгын газарт 34.7 сая төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 11.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон,
- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 82.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

• 822511000441

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.1, 41.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 14 дүгээр тогтоолтой тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 858.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 899.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 104.8 хувиар биелүүлжээ.

Тайлант онд аймгийн төсвөөс 1,083.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байхад бэлэг дурсгал, шагналд төсөв зарцуулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв тогтмол зардлын нийт 166.9 сая төгрөгийн, урсгал засварын 19.0 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 20 зорилт, 80 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 92.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 552,766.2 | 959,924.5 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 263,746.2 | 675,039.3 |
| 3 | АВЛАГА | 177,717.2 | 128,245.8 |
| 4 | БАРАА МАТЕРИАЛ | 98,830.4 | 103,975.4 |
| 5 | НӨӨЦИЙН БАРАА | 12,472.0 | 42,164.0 |
| 6 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | - | 10,500.0 |
| 7 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,780,513.7 | 1,878,283.9 |
| 8 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,780,513.7 | 1,878,283.9 |
| 9 | Биет хөрөнгө | 1,665,855.2 | 1,763,937.9 |
| 10 | Биет бус хөрөнгө | 114,658.5 | 114,346.0 |
| 11 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 2,333,279.9 | 2,838,208.4 |
| 12 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 168,224.5 | 190,499.7 |
| 13 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 168,224.5 | 190,499.7 |
| 14 | Өглөг | 168,224.5 | 190,499.7 |
| 15 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,165,055.4 | 2,647,708.7 |
| 16 | Засгийн газрын хувь оролцоо | 2,165,055.4 | 2,647,708.7 |
| 17 | Засгийн газрын оруулсан капитал | 210,318.0 | 210,318.0 |
| 18 | Хуримтлагдсан үр дүн | 1,840,183.9 | 2,328,589.0 |
| 19 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 114,553.5 | 108,801.7 |
| 20 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 2,333,279.9 | 2,838,208.4 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 3,077,648.3 | 2,564,125.7 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 596,649.9 | 899,969.9 |
| 3 | Орлогын албан татвар | 424,795.1 | 516,604.2 |
| 4 | Хувь хүний орлогын албан татвар | 437,435.7 | 536,332.2 |
| 5 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (12,640.6) | (19,728.0) |
| 6 | Хөрөнгийн албан татвар | 59,090.6 | 83,225.6 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|----|--|-------------|-------------|
| 7 | Бусад татвар, төлбөр, хураамж | 112,764.2 | 300,140.1 |
| 8 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 801,944.6 | 1,664,155.8 |
| 9 | Тусламжийн орлого | - | 1,108,655.2 |
| 10 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,679,053.9 | - |
| 11 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,347,664.4 | 1,984,675.3 |
| 12 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,347,664.4 | 1,984,675.3 |
| 13 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,293,774.5 | 1,967,467.1 |
| 14 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 701,572.7 | 792,312.6 |
| 15 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,783.7 | 99,255.3 |
| 16 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 592,645.2 | 718,459.1 |
| 17 | Хангамж, бараа материалын зардал | 44,240.3 | 33,190.1 |
| 18 | Эд хогшил, урсгал засварын зардал | 489,894.4 | 6,795.2 |
| 19 | Томилолт, зочны зардал | 19,596.0 | 18,119.2 |
| 20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 53,233.6 | 57,592.1 |
| 21 | Бараа үйлчилгээний бусад зардал | 304,808.7 | 241,743.6 |
| 22 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 53,889.9 | 17,208.2 |
| 23 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 729,984.0 | 579,450.3 |
| 24 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 539,068.5 | 89,360.0 |
| 25 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (539,068.5) | (89,360.0) |
| 26 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 190,915.5 | 490,090.3 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|--|-------------------------|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,974,139.9 | 1,974,139.9 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 4,370.6 | 4,370.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,978,510.5 | 1,978,510.5 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (4,370.6) | (4,370.6) |
| 5 | Тайлант үеийн үр дүн | 190,915.5 | 190,915.5 |
| 6 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,165,055.4 | 2,165,055.4 |
| 7 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,165,055.4 | 2,165,055.4 |
| 8 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (1,685.2) | (1,685.2) |
| 9 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,163,370.2 | 2,163,370.2 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|----|--|-------------|-------------|
| 10 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (5,751.8) | (5,751.8) |
| 11 | Тайлант үеийн үр дүн | 490,090.3 | 490,090.3 |
| 12 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 2,647,708.7 | 2,647,708.7 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|----|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,343,324.2 | 2,358,332.6 |
| 2 | ТАТВАРЫН ОРЛОГО | 596,649.9 | 899,969.9 |
| 3 | Орлогын албан татвар | 424,795.1 | 516,604.2 |
| 4 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (12,640.6) | (19,728.0) |
| 5 | Хөрөнгийн албан татвар | 59,090.6 | 83,225.6 |
| 6 | Бусад татвар, төлбөр, хураамж | 112,764.2 | 300,140.1 |
| 7 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 5,981.2 | 14,497.4 |
| 8 | Газрын төлбөр | 106,783.0 | 112,920.0 |
| 9 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 172,722.7 |
| 10 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 67,620.5 | 1,458,362.7 |
| 11 | Нийтлэг татварын бус орлого | 67,620.5 | 154,471.0 |
| 12 | Тусламжийн орлого | - | 1,108,655.2 |
| 13 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 195,236.5 |
| 14 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,679,053.9 | - |
| 15 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,032,144.1 | 1,792,149.0 |
| 16 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,032,144.1 | 1,792,149.0 |
| 17 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,975,983.3 | 1,774,940.8 |
| 18 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 710,101.7 | 791,355.9 |
| 19 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 87,783.7 | 99,255.3 |
| 20 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 483,827.6 | 658,955.6 |
| 21 | Хангамж, бараа материалын зардал | 41,780.0 | 30,590.1 |
| 22 | Эд хогшил, урсгал засварын зардал | 431,487.6 | 46,170.2 |
| 23 | Томилолт, зочны зардал | 19,596.0 | 18,119.2 |
| 24 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 59,933.6 | 81,784.1 |
| 25 | Бараа үйлчилгээний бусад зардал | 141,473.2 | 48,710.5 |
| 26 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 56,160.8 | 17,208.2 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|----|---|-------------|-------------|
| 27 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 311,180.1 | 566,183.6 |
| 28 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 337,768.5 | 154,890.9 |
| 29 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 337,768.5 | 154,890.9 |
| 30 | Дотоод эх үүсвэрээр | 337,768.5 | 154,890.9 |
| 31 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (337,768.5) | (154,890.9) |
| 32 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (26,588.4) | 411,292.7 |
| 33 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 290,334.9 | 263,746.6 |
| 34 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 263,746.6 | 675,039.3 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|------------|--|-------------|-----------------------------|------------|-------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,424,792.0 | 2,332,062.1 | 92,729.9 | 96.2 |
| 11 | Татварын орлого | 857,707.6 | 899,969.9 | (42,262.3) | 104.9 |
| 110 | Орлогын албан татвар | 497,818.8 | 516,604.2 | (18,785.4) | 103.8 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 517,546.8 | 536,332.2 | (18,785.4) | 103.6 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 419,088.0 | 441,511.1 | (22,423.1) | 105.4 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 5,458.8 | 6,627.9 | (1,169.1) | 121.4 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 50,000.0 | 45,196.2 | 4,803.8 | 90.4 |
| 110008 | Шууд бус орлого | 43,000.0 | 42,996.9 | 3.1 | 100.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (19,728.0) | (19,728.0) | 0.0 | 100.0 |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (19,728.0) | (19,728.0) | 0.0 | 100.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 89,148.8 | 83,225.6 | 5,923.2 | 93.4 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 3,414.7 | 8,680.5 | (5,265.8) | 254.2 |
| 113002 | Бууны албан татвар | 1,740.0 | 1,950.0 | (210.0) | 112.1 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 83,994.1 | 72,595.1 | 11,399.0 | 86.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 270,740.0 | 300,140.1 | (29,400.1) | 110.9 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 5,700.0 | 14,497.4 | (8,797.4) | 254.3 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 3,500.0 | 12,836.1 | (9,336.1) | 366.7 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 2,200.0 | 1,661.3 | 538.7 | 75.5 |
| 1181 | Газрын төлбөр | 98,000.0 | 112,920.0 | (14,920.0) | 115.2 |
| 118101 | Газрын төлбөр | 98,000.0 | 112,920.0 | (14,920.0) | 115.2 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 167,040.0 | 172,722.7 | (5,682.7) | 103.4 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 167,040.0 | 169,517.9 | (2,477.9) | 101.5 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | |
|--------|---|-------------|-------------|-------------|--------|
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | - | 3,204.8 | (3,204.8) | |
| 12 | Татварын бус орлого | 1,567,084.4 | 1,432,092.2 | 134,992.2 | 91.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 51,817.1 | 153,721.0 | (101,903.9) | 296.7 |
| 120003 | Торгуулийн орлого | 905.1 | 3,074.0 | (2,168.9) | 339.6 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 1,620.0 | 45,883.5 | (44,263.5) | 2832.3 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 49,292.0 | 104,763.5 | (55,471.5) | 212.5 |
| 122 | Тусламжийн орлого | 1,083,134.7 | 1,083,134.7 | - | 100.0 |
| 122003 | Аймаг нийслэлээс авсан татаас | 1,083,134.7 | 1,083,134.7 | - | 100.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 234,924.0 | - | 234,924.0 | 0.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 197,208.6 | 195,236.5 | 1,972.1 | 99.0 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 197,208.6 | 195,236.5 | 1,972.1 | 99.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,424,792.0 | 1,910,299.2 | 514,492.8 | 78.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,909,373.3 | 1,771,648.3 | 137,725.0 | 92.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,874,173.3 | 1,754,440.0 | 119,733.3 | 93.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 837,139.4 | 791,355.9 | 45,783.5 | 94.5 |
| 210101 | Үндсэн цалин | 457,669.4 | 438,272.7 | 19,396.7 | 95.8 |
| 210102 | Нэмэгдэл | 375,600.0 | 350,257.6 | 25,342.4 | 93.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,400.0 | 2,825.6 | 574.4 | 83.1 |
| 210104 | Урамшуулал | 470.0 | - | 470.0 | 0.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 104,633.7 | 99,255.3 | 5,378.4 | 94.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,606.9 | 67,143.4 | 3,463.5 | 95.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,106.8 | 8,565.3 | 541.5 | 94.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,153.3 | 3,882.6 | 270.7 | 93.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,153.3 | 3,883.6 | 269.7 | 93.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,613.4 | 15,780.3 | 833.1 | 95.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 675,822.2 | 658,955.6 | 16,866.6 | 97.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 43,944.7 | 34,192.4 | 9,752.3 | 77.8 |
| 210302 | Түлш, халаалт | 625,477.5 | 618,363.2 | 7,114.3 | 98.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,400.0 | 6,400.0 | 0.0 | 100.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,592.4 | 24,242.0 | 7,350.4 | 76.7 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,518.0 | 2,443.1 | 1,074.9 | 69.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,160.4 | 18,365.8 | 4,794.6 | 79.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,600.0 | 2,199.6 | 400.4 | 84.6 |
| 210404 | Ном, хэвлэл | 500.0 | - | 500.0 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120.0 | - | 120.0 | 0.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,694.0 | 1,233.5 | 460.5 | 72.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 47,183.3 | 47,175.0 | 8.3 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500.0 | 2,500.0 | - | 100.0 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | |
|--------|--|-----------|-----------|-----------|-------|
| 210604 | Урсгал засвар | 44,683.3 | 44,675.0 | 8.3 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 20,600.0 | 18,119.2 | 2,480.8 | 88.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,600.0 | 18,119.2 | 2,480.8 | 88.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 112,992.0 | 78,626.6 | 34,365.4 | 69.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 108,062.0 | 75,840.8 | 32,221.2 | 70.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300.0 | 300.0 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,430.0 | 493.6 | 936.4 | 34.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150.0 | 66.0 | 84.0 | 44.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,250.0 | 1,236.5 | 1,013.5 | 55.0 |
| 210807 | Газрын төлбөр | 800.0 | 689.7 | 110.3 | 86.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,210.3 | 36,710.5 | 7,499.8 | 83.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,210.3 | 33,748.2 | 5,462.1 | 86.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,000.0 | 2,962.3 | 2,037.7 | 59.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,200.0 | 17,208.2 | 17,991.8 | 48.9 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 16,000.0 | 15,758.2 | 241.8 | 98.5 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 16,000.0 | 15,758.2 | 241.8 | 98.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19,200.0 | 1,450.0 | 17,750.0 | 7.6 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,200.0 | 1,450.0 | 17,750.0 | 7.6 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 387,664.1 | 138,650.9 | 249,013.2 | 35.8 |
| 223001 | Бусад хөрөнгө | 387,664.1 | 138,650.9 | 249,013.2 | 35.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 127,754.6 | - | 127,754.6 | 0.0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 127,754.6 | - | 127,754.6 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 262,746.5 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 673,289.3 | | |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

| Дансны код | Дансны нэр, төрөл | Гүйцэтгэл |
|------------|--|-----------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 44,600.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 44,600.7 |
| 122 | Тусламжийн орлого | 44,600.7 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 44,600.7 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 44,600.7 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 26,445.7 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,155.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 36,740.7 |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | |
|--------|--|-----------|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 36,740.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 36,740.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,348.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,813.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,535.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,495.2 |
| 210604 | Урсгал засвар | 1,495.2 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 16,897.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,897.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,000.0 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 7,860.0 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (7,860.0) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (7,860.0) |

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Залруулагдаагүй нийт 71.3 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 82.2 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 71.3 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

3.1.1 Харьяа байгууллагууд

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 4 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС, Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

3.1.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ХХС, БХНСС, ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 175.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 4 алдааг залруулж, 10.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 21.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 23.9 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1.3 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар 26.8 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 71.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчил арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж байна.

3.3 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 82.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 10.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.1 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага, 50.7 сая төгрөгийн зөрчилд холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлого 4.8 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 11.4 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.5 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", "Сумын 2025 оны төсөв тодотгон батлах тухай" Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

Хоёр. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын Засаг даргын Тамгын газарт 34.7 сая төгрөгийн, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 11.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;", "Сумын 2025 оны төсвийн тодотгол батлах тухай" Чандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 14 дүгээр тогтоолтой нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг бүрэн олгох.

Гурав. Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас бэлэг дурсгал, шагналд 8.8 сая төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 -ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|------------------|--------------------------|--------------|------------|------------------|--------------|----------|----------|----------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Чандмань сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Чандмань сумын ОНХС | 3 | 175,090.9 | 3 | 175,090.9 | - | - | 3 | 175,090.9 | - | - | - | - |
| Чандмань сумын ХХС | 1 | 645.7 | | | 1 | 645.7 | 1 | 645.7 | - | - | - | - |
| Дүн | 4 | 175,736.6 | 3 | 175,090.9 | 1 | 645.7 | 4 | 175,736.6 | - | - | - | - |

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Бүгд | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзах | Түүвэрт | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|------|-------------|----------------|-------|---------------------------|---------|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|---------|----------|--------------------------------------|-----|---|---------------------|
| | | | | | | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо |
| Чандмань сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан | 1 | - | 1 | - | - | - | 4.0 | 71,265.2 | | | 1.0 | - | 3.0 | 71,265.2 | - | - | - | - |
| Чандмань сумын Засаг даргын Тамгын газар | 1 | - | 1 | - | - | - | 3.0 | 26,837.8 | - | - | - | - | 3.0 | 26,837.8 | - | - | - | - |
| Чандмань сумын | | | | | | | - | - | | | | | | | - | - | - | - |

Чандмань сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|------------------------------------|----------|----------|----------|---|---|----------|-------------|------------------|------------|-----------------|------------|----------------|------------|------------------|----------|----------|----------|----------|
| иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | - | - | - | - | 1 | | | | | | | | | - | - | - | - |
| Чандмань сумын ОНХС | 1 | - | - | - | - | 1 | 2.0 | 29,514.1 | | | 1.0 | 7,764.1 | 1.0 | 21,750.0 | - | - | - | - |
| Чандмань сумын БХНСС | 1 | - | - | - | - | 1 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Чандмань сумын ХХС | 1 | - | - | - | - | 1 | 2.0 | 12,505.8 | 1.0 | 10,395.8 | | | 1.0 | 2,110.0 | - | - | - | - |
| Дүн | 6 | - | 2 | | | 4 | 11.0 | 140,122.9 | 1.0 | 10,395.8 | 2.0 | 7,764.1 | 8.0 | 121,963.0 | - | - | - | - |

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөг)

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--------------------|-------------|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|----------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Чандмань сумын ХХС | 1 | 13,388.0 | - | - | 1 | 13,388.0 | - | - |
| Дүн | 1 | 13,388.0 | - | - | 1 | 13,388.0 | - | - |